


Дундговь аймгийн 2019-2021 оны цаг агаар, уур амьсгалын тойм

Дундговь аймаг нь Монгол улсын нутгийн төв хэсэгт талархаг нутагт говь хээрийн бүсийн зааг дээр оршдог. Нутгийн хамгийн өндөр цэг нь 1926 м өндөр, Дэлгэрхангай уул юм. Мөн Их, Бага газрын чулуу зэрэг уулс бий. Дундговь аймгийн нутагт Онгийн голоос өөр том гол, нуур байхгүй.


Дундговь аймгийн нутаг боржин чулуутай цохио, толгод, бэсрэг уулс бvхий ухаа гvвээрхэг тэгшивтэр нутагт хамаарна. Нийт газар нутгийн талбай 74,690 км квадрат. Далайн түвшнээс дээш 1100-1377 метрт өргөдсөн байдаг.

Агаарын температур: Дундговь аймгийн олон жилийн агаарын дундаж температур /1991-2021он/ нь 1,1...4,5 градусын хооронд хэлбэлздэг байна. 2019 онд 2,0...4,8 градус, 2020 онд 1,7...4,7, 2021 онд 2,4...5,4 градус байгааг олон жилийн дундажтай харьцуулахад 2019 онд Хулд, Дэлгэрхангай сумдаар -0,3 градусаар хүйтэн бусад нутгаар 0,0...1,3 градусаар дулаан, 2020 онд Эрдэнэдалай, Хулд, Дэлгэрхангай, Дэрэн сумдаар -0,1...-0,2 градусаар хүйтэн, бусад нутгаар 0,2...1,2 градусаар дулаан, 2021 онд Хулд, Дэлгэрхангай сумдаар -0,1 градусаар хүйтэн, бусад нутгаар 0.3...1,9 градусаар дулаан байсан байна. (Зураг 1).




Зураг 1. Дундговь аймгийн агаарын дундаж температур /2019-2021он/

Агаарын жилийн дундаж температурыг дундчилж үзвэл 2019 онд 0,6 градус, 2020 онд 0,4 градус, 2021 онд 1,0 градусаар олон жилийн дундажаас дулаан байжээ (Зураг 2).



Зураг 2. Дундговь аймгийн жилийн агаарын дундаж температурыг олон жилийн дундаж температуртай харьцуулсан /2019-2021он/

Агаарын хамгийн их температур нь 2019 онд 32,7...37,2 градус хүрч агаарт +30 градусаас дулаан 11-45 өдөр, 2020 онд 32,7...36,7 градус хүрч агаарт +30 градусаас дулаан 10-38 өдөр, 2021 онд 33,1...36,2 градус хүрч агаарт +30 градусаас дулаан 9-35 өдөр байсан. 2019 онд Гурвансайхан, Хулд суманд 35,6...37,2 градус хүрч агаарт +30 градусаас дулаан өдөр 45 ажиглагдсан байна. (Зураг 3).




Зураг 3. Агаарын хамгийн их температурын тархалт /2019.07/



Зураг 4. Агаарт +30 градусаас дулаан өдрийн тоо /2019-2021он/


Агаарын хамгийн бага температур нь 2019 онд -26,1...-38,7 градус хүрч агаарт -30 градусаас хүйтэн 1-24 өдөр, 2020 онд -28,5...-35,9 хүрч агаарт -30 градусаас хүйтэн 1-29 өдөр, 2021 онд -30,8...38,4 хүрч агаарт -30 градусаас хүйтэн 1-10 өдөр ажиглагдсан байна. 2019 онд Эрдэнэдалай суманд -38,7 градус хүрч агаарт -30 градусаас хүйтэн өдөр 24 ажиглагдсан байна (Зураг 5).



Зураг 5. Агаарт -30 градусаас хүйтэн өдрийн тоо /2019-2021он/


Хур тунадас: Дундговь аймгийн нутгаар олон жилийн дундажаар 96,1-209 мм хур тунадас унадаг байна. 2019 онд нийт нутгаар жилдээ 44,1-163,5 мм хур тунадас орсон бөгөөд Говь-Угтаал, Хулд сумдаар олон жилийн дунджаас ахиу, Цагаандэлгэр, Гурвансайхан, Дэрэн, Өндөршил, Баянжаргалан сумдаар олон жилийн дунджаас бага, бусад сумдаар олон жилийн дунджийн орчим орсон. 2020

онд нийт нутгаар жилдээ 25,7-159,1 мм хур тунадас орсон бөгөөд Хулд, Өндөршил сумдаар олон жилийн дунджаас ахиу, Говь-Угтаал, Луус олон жилийн дунджийн орчим, бусад сумдаар олон жилийн дунджаас бага хур тунадас орсон. 2021 онд нийт нутгаар жилдээ 55,7-244,8 мм хур тунадас орсон бөгөөд Эрдэнэдалай, Говь-Угтаал, Сайхан-Овоо, Хулд, Дэлгэрхангай сумдаар олон жилийн дунджаас ахиу, Өндөршил суманд олон жилийн дунджаас бага, бусад сумдаар олон жилийн дунджийн орчим орсон байна. Жилийн нийлбэр хур тунадасны хэмжээгээр хамгийн их нь 2019 онд Луус суманд 163,5 мм, 2020 онд Хулд суманд 159,1 мм, 2021 онд Цагаандэлгэр суманд 244,8 мм хур тунадас орсон байна. Хамгийн бага нь 2019 онд Баянжаргалан суманд 44,1 мм, 2020 онд Сайхан-Овоо суманд 25,7 мм, 2021 онд Өндөршил суманд 55,7 мм хур тунадас орсон (Зураг 6).




Зураг 6. Жилийн нийлбэр хур тунадас, мм /2019-2021он/

Хур тунадасыг 4-10 дугаар сарыг дулааны улирал, 11-03 дугаар сарыг хүйтний улирал гэж авч үзвэл дулааны улиралд 2019 онд 37,4-154,3 мм хур тунадас, 2020 онд 20,4-156,2 мм, 2021 онд 51,9-238,5 мм хур тунадас орсон бөгөөд хүйтний улиралд 2019 онд 2,3-13,8 мм хур тунадас, 2020 онд 2,9-14,3 мм, 2021 онд 1,5-6,4 мм хур тунадас орсон. Үүнээс үзвэл жилийн нийлбэр хур тунадасны ихэнхи хувийг дулааны улирлын хур тунадас эзэлдэг бөгөөд энэ нь халалтаас үүсдэг конвекцийн үзэгдлүүд, мөн дулааны улиралд явагддаг цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаатай шууд холбоотой юм.




Зураг 7. Дулааны улирлын хур тунадас /2019-2021он/




Зураг 8. Хүйтний улирлын хур тунадас /2019-2021он/




Сүүлийн 5 жилийн буюу 2017-2021 оны Аюултай үзэгдлийн давтамжаас харахад 3-5 сард буюу хаврын улиралд нийт аюултай үзэгдлийн 60 орчим хувь нь ажиглагддаг байна.



Харин сүүлийн 5 жилээс хамгийн их аюулт болон гамшигт үзэгдэл ажиглагдсан нь 2021 он бөгөөд энэ дундаа 3 дугаар сарын 14-ний Гамшигт үзэгдэл дийлэнх хувийг эзэлнэ.



Дундговь аймгийн нутгаар 2003-2021 оны 10-р сарын 1-нийг хүртэлх хугацаанд ажиглагдсан аюултай үзэгдлийн судалгаанаас харахад нийт /6552/ аюултай үзэгдэл ажиглагдсаны 43,8% нь хүчтэй салхи, 25,5% нь цасан болон орон шуурга, 14,9% нь шороон шуурга, 15,8% нь нөөлөг салхи, нойтон цас, цас, мөндрийн аюул эзэлж байна.



Харин байгалийн гамшигт үзэгдэл буюу онц аюултай үзэгдлийн мэдээллийг авч үзвэл (2003-2021 он) 23 нь 52,3% нь шороон шуурга, хүчтэй салхи нь 11 буюу 25%, цасан болон орон шуурга нь 10 буюу 22,7% эзэлж байна.

Дундговь аймгийн УЦУОШТөвийн ЦУОТХэлтэс